



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 2021

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч нийт 57,585.4 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Геологийн судалгааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал (Н.Ганболд)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2.Байгууллагын үйлдвэрлэл, эдийн засгийн үр ашгийг сайжруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

2.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын тайланг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

2.4.Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байхаар заасныг мөрдөж ажиллах;

2.5.Гадаад болон дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

2.6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 116 дугаар тогтоолоор батлагдсан “Геологийн судалгааны төв” ТӨҮГ-ын захиргааны албан тушаалын жагсаалтыг мөрдөж ажиллах,

132001496

2.7.Хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж ажилласан ерөнхий нягтлан бодогч Т.Батбилэг, эрх зүйч, хүний нөөцийн менежер Ж.Цогтгэрэл нарт хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллах;

3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
26-р дугаар тогтоолын
хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хуулийн дагуу суутгаж төсөвт төвлөрүүлээгүй ХХОАТ	Захирал Х.Ганболд Ерөнхий ня-бо Т.Батбилэг	8,278.00	ХХОАТ-ын тухай хуулийг мөрдөж ажиллах Төсөвт төвлөрүүлэх
2	Дээд шатны байгууллагын томилолтын зардлыг хариуцсан	Захирал Х.Ганболд Ерөнхий ня-бо Т.Батбилэг	11,370.00	Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах Тогтоолын дагуу зардлыг холбогдох албан тушаалтнаар төлүүлэх
3	ТӨБЗГ-аас баталж өгсөн орон тооноос гадуур авсан ажиллагсдыг цалин	Захирал Х.Ганболд Ерөнхий ня-бо Т.Батбилэг	33,874.40	Төсвийн хууль, ТӨБЗГ-тай байгуулсан контрактын гэрээг мөрдөж ажиллах,
4	Хууль бусаар олгосон жилийн үр дүнгийн урамшуулал	Захирал Х.Ганболд Ерөнхий ня-бо Т.Батбилэг	4,063.00	4,063.0 мян төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэх,
	Дүн		57,585.40	